

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

ХҮИ.9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:

1. 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар “хангалтгүй” буюу 27.7 хувьтай байх тул тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах;


1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах;

1.2. өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх;

1.3. худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах;

1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10¹-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

2. Цахим худалдан авах ажиллагааг сайжруулах, статистик тоон мэдээллийн давхардалгүй, үнэн зөв байдлыг хангах, ерөнхий гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор цахим дэлгүүрийн хэвийн ажиллагааг хангаж, холбогдох гарын авлагыг боловсруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР